



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**  
Төрийн Өмчит Хувьцаат Компани

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 4/25

Улаанбаатар хот

Г Дүрэм батлах тухай Г

Төмөр замын тээврийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2, 19 дүгээр зүйлийн 19.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоол, Компанийн дүрмийн 8.12.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын Төмөр Зам” ТӨХК-ийн Хяналт шалгалтын дүрэм”-ийг хавсралтаар баталсугай
2. Энэхүү дүрмийг мөрдөж, хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг Хяналт шалгалтын газрын дарга /М.Амарсайхан/-д даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Б.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.БАТСҮХ



20200171

Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2020 оны 03 сарын 15 өдрийн 12 тоот тушаалын хавсралт



## “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмээр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн /цаашид “компани” гэх/-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн зорилго, хяналт шалгалтын чиглэл, хэлбэр, зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2. Хяналт шалгалтын зорилго нь компанийн суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавьж, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид болон компанийн хэрэгжүүлж буй төслийн барилга угсралтын ажлын явц, гүйцэтгэлд учирч болзошгүй аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлэн холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх замаар компанийн болон төмөр замын тээврийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангуулахад оршино.

1.3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал, компанийн дотоодод мөрдөх дүрэм, журмыг удирдлага болгоно.

1.4. Хяналт шалгалтын үйл ажиллагааны зардал, санхүүжилтийг компанийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.

1.5. Хяналт шалгалтын үйл ажиллагаа хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

1.6. Энэхүү дүрэмд заасан хяналт шалгалтыг компанийн хяналт шалгалтын нэгж хэрэгжүүлнэ.

### ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХЭЛБЭР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Хяналт шалгалтын үйл ажиллагааг дараах үндсэн чиглэлээр хэрэгжүүлнэ.

- А. Төмөр замын тээврийн аюулгүй байдал;
- В. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт;
- С. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт.

2.1.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдал:

2.1.1.1. Компанийн төмөр замын тээврийн үйл ажиллагаанд дараах чиглэлээр аюулгүй байдлын нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж буй эсэхэд хяналт тавьж холбогдох албан тушаалтан, удирдлагад зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- а) Хүний амь нас, эрүүл мэнд;
- б) Ачаа, тээш, ачаан тээш тээвэрлэлт;
- в) Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, төмөр замын тээврийн бусад хэрэгслийн хөдөлгөөн;

d) Төмөр замын техник хэрэгсэл, суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл;

e) Төмөр замын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;

f) Хүрээлэн байгаа орчны хамгаалалт.

2.1.1.2. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэвийн үйл ажиллагааг хангах талаарх Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, төмөр замын нийтлэг багц дүрэм, журам, стандарт, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.1.3. Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, тэдгээрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.1.4. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг зохион байгуулах;

2.1.1.5. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнд хэвийн бус нөхцөл үүссэн шалтгаан, нөхцөл байдал, үр дагаврыг судлан, дүн шинжилгээ хийж, гарсан зөрчил дутагдалыг засаж хэвийн болгох хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавин эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.1.1.6. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнд гарсан аливаа осол, ссатал, зөрчлийг арилгах, хэвийн ажиллагааг сэргээх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах;

2.1.1.7. Төмөр замын өртөө, зөрлөг, төмөр замын зурвас газарт аюулгүй ажиллагааны шаардлагыг хангуулах, аюулгүй болон аюултай бүсийн дэглэм сахиулах;

2.1.1.8. Хатуу тооцоот багаж хэрэгслийн бүртгэл, хадгалалтад хяналт тавих;

2.1.1.9. Хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой гарсан осол, гологдол, зөрчилд дүн шинжилгээ хийж, түүнийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаанд шинэ технологи, тэргүүний арга барил нэвтрүүлэх талаар санаачилгатай ажиллан, заавар, зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх;

2.1.1.10. Тусгай галт тэргийг бэлтгэх, аялуулах үйл ажиллагаанд хяналт тавих;

2.1.1.11. Салбар, нэгжийн удирдлагаас хөдөлмөрийн хамт олны сахилга хариуцлагыг бэхжүүлэх, идэвх санаачилгыг өрнүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажилд хяналт тавих, зөвлөн туслах;

2.1.1.12. Компанийн хөдлөх бүрэлдэхүүн орж үйлчилдэг байгууллага, аж ахуйн нэгжийн дагнасан хэрэглээний замын үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгуулах арга хэмжээ авахуулах.

#### *2.1.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт*

2.1.2.1. Компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах болон барих, арчлах, засварлах ажиллагаанд хяналт тавих;

2.1.2.2. Төмөр замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг төсөв, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих, зөвөлгөө өгөх;

2.1.2.3. Төмөр замын тээврийн салбарын норм норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, боловсронгуй болгох санал боловсруулж, удирдлагад танилцуулах;

2.1.2.4. Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн ажлын гүйцэтгэлийн явцад чиглэл тус бүрээр хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд тухайн үйл ажиллагааг түр зогсоож хэвийн үйл ажиллагааг хангуулах;

2.1.2.5. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Монгол Улсын холбогдох хуультогтоомж, дүрэм, журам, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, технологийг ноцтой зорчиж өндөр эрсдэл үүсгэж байгаа аюулийн этгээд, иргэний үйл ажиллагааг зогсоох, цаашид ажиллуулах эсэх талаар удирдлагад санал гаргах.

### *2.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт*

2.1.3.1. Компанийн газар, нэгжийн ажлын байрны ХАБЭА-н нөхцөл байдал, ажил гүйцэтгэх үед аюулгүй ажиллагааг хангаж буй байдал, хөдөлмөрийн эрүүл ба аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх талаарх ажилтнуудын ХАБЭА-н ажил үүргийн биелэлтэд хяналт, шалгалт хийх;

2.1.3.2. Төмөртэй өртөө болон өртөөний сүүршилын орчны агаар, хөрсний бохирдол, хог хаягдлын зайлуулалт, унд, ахуйн усны хангамж хүрэлцээ, чанар, аюулгүй байдалд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орчны бохирдол болон унд ахуйн усаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангуулах;

2.1.3.3. Халдварт өвчинтэй тэмцэх Монгол Улсын үндэсний хөтөлбөр, шинэ ба дахин сэргэж буй хурц халдварт өвчнүүд болон олон улсын хөл хориот хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар гарсан тушаал, шийдвэр, стандартуудын хэрэгжилт, халдвар судлалын тандалтад хяналт тавих, эрсдэл ихтэй эмгэгээс урьдчилан сэргийлэх, өвчний сэжиг илрэх, өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

2.1.3.4. Шинээр баригдаж байгаа болон өөрчлөн засварласан компанийн нийгэм хангамж, үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлийн объект, барилга байгууламж нь эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавих;

2.1.3.5. Үйл ажиллагааны чиглэл бүрээр хяналтын ажилтанд хууль, дүрэм, журам, стандарт, хяналтын хуудсыг сурталчлан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, сургалт зохион байгуулах.

### *2.1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ*

2.1.4.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын туушаалын биелэлтийг холбогдох нэгж, албан тушаалтнаар тухай бүр гаргуулан авч нэгтгэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

2.1.4.2. Холбогдох байгууллагаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу тухай бүр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж удирдлагад танилцуулах;

2.1.4.3. Гүйцэтгэх захирлын А тушаалын хэрэгжилтийн тайланг холбогдох нэгжээс гаргуулан авч, зохих журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн компанийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэгдсэн санал, зөвлөмж боловсруулах, удирдлагад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

*2.2. Хяналт шалгалтыг дор дурдсан аргаар явуулна:*

2.2.1. Хяналт шалгалтын объектод үзлэг хийх, хяналтын хуудсаар эрсдлийг үнэлэх;

2.2.2. Баримт бичгийг хянан үзэх;

2.2.3. Хүрээлэн буй орчин, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, халдвар, хамгаалалтын шаардлага, бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох зорилгоор хэмжилт хийх, дээж авч шинжилгээнд хамруулах;

2.2.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний машин механизм, тоног төхөөрөмж, даралтат сав, шугам хоолой зэрэгт туршилт, магадлал хийх;

2.2.5. Хяналт шалгалтын үйл явцад илэрсэн зөрчил, дутагдал, үр дүнг гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх зэрэг боломжит аргаар баримтжуулах;

2.2.6. Тайлбар, тодорхойлолт, мэдээлэл, судалгаа, холбогдох баримт бичиг гаргуулан авах;

2.2.7. Хуульд заасан бусад арга.

*2.3. Хяналт шалгалтыг дараах хэлбэрээр явуулна:*

2.3.1. Шалгалт хийх;

2.3.2. Урьдчилан сэргийлэх шалгалт хийх;

2.3.3. Тандалт судалгаа хийх;

2.3.4. Хяналт шинжилгээ хийх;

2.3.5. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх.

2.4. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилна. Мөн компанийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хөдлөх бүрэлдэхүүнийг өвөл, зуны тээвэрт бэлтгэх ажилд хяналт тавих, хүлээн авах үед хяналт шалгалт явуулна.

*2.5. Хяналт шалгалтын үе шат*

2.5.1. Хяналт шалгалтыг хяналт шалгалтад бэлтгэх, эхлэх, гүйцэтгэх, дүгнэх гэсэн үе шатаар хэрэгжүүлнэ.

*2.6. Хяналт, шалгалтын нэгжийн зохион байгуулалт*

2.6.1. Хяналт шалгалтын нэгж нь компанийн Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулах ба газрын дарга удирдана.

2.6.2. Хяналтын ажилтан нь тухайн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан, хяналт шалгалтын ажлын туршлагатай байна. Хяналтын ажилтныг газрын даргын оруулсан саналыг үндэслэн Дэд захиралтай зөвшилцөн, Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.

2.6.3. Хяналт шалгалтын нэгж нь хэмжилт, туршилт, судалгаа, шинжилгээний зориулалттай лаборатори, бусад нэгжтэй байж болно.

2.7. Хяналт шалгалтын явцад үйлдэх баримт бичиг дараах төрөлтэй байна:

- 2.7.1. Удирдамж;
- 2.7.2. Мэдэгдэх хуудас;
- 2.7.3. Шалгалтын тэмдэглэл;
- 2.7.4. Акт;
- 2.7.5. Албан шаардлага;
- 2.7.6. Дүгнэлт;
- 2.7.7. Хяналт, шалгалтад хамруулсан тухай мэдэгдэл;
- 2.7.8. Зөвлөмж.

### ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

3.1. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэгж нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Компанийн ажил үйлчилгээ болон галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн асуудлыг компанийн удирдлагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Компанийн галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдсон хэтийн болон ойрын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулахад санал оруулах;

3.1.3. Компанийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, салбар замд эрсдэл учруулсан гадны байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн таслан зогсоох, эрх бүхий байгууллагад мэдэгдэн шийдвэрлүүлэх;

3.1.4. Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, компанийн Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрийг ноцтой зөрчсөн ажилтанд Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журмын дагуу сахилгын шийтгэл ноогдуулах саналыг холбогдох дээд шатны удирдлагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.5. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, компанийн дотоодод мөрдөж буй дүрэм, холбогдох журам, заавар энэхүү дүрмийг дагаж мөрдөх;

3.1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийг биелүүлэх;

3.1.7. Хяналт шалгалтыг мэргэжлийн өндөр түвшинд явуулах ба гарсан зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажиллах;

3.1.8. Хяналт шалгалтын нэгжийн ажилтнуудыг мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамруулан мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, дадлагажуулах;

3.1.9. Хяналт шалгалтын нэгжийн ажлын тайлан мэдээг Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа яам, агентлагт зохих журмын дагуу хүргүүлж, мэргэжлийн чиглэл авч ажиллах;

3.1.10. Улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээний асуудлыг харьяа яам, агентлаг, мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

### ДӨРӨВ. ХЯНАЛТЫН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

#### **4.1. Хяналтын ажилтны эрх:**

4.1.1.Хяналт шалгалтыг явуулахдаа газар, нэгжийн объектод саадгүй нэвтрэх, тэдгээрийн удирдлага, ажилтнаас шаардлагатай мэдээ, судалгааг бичгээр болон цахим хэлбэрээр гаргуулан авах, ажил байдлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

4.1.2.Хяналт шалгалтаар илэрсэн ноцтой зөрчил дутагдлыг арилгуулахаар акт, албан шаардлага, дүгнэлт, зөвлөмж үйлдэх, үүрэг даалгавар өгөх;

4.1.3.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай байр, тоног төхөөрөмж, машин техник хэрэгслийг ашиглах;

4.1.4.Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах, төлбөр барагдуулах талаар Захирлын зөвлөлд санал оруулж шийдвэрлүүлэх;

4.1.5.Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

#### **4.2. Хяналтын ажилтны үүрэг:**

4.2.1.Өөрийн үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг хангах, бодитой байх зэрэг нийтлэг зарчмуудаас гадна Хяналт шалгалтын ажилтны ёс зүйн дүрмийг мөрдлөг болгоно.

4.2.2.Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн түвшинд хяналт шалгалтыг гүйцэтгэх, аливаа дүгнэлтийг нотлох баримт, судалгаагаар баталгаажуулах;

4.2.3.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөлийг судалж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

4.2.4.Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг мөрдүүлэх, сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

4.2.5.Компанид мөрдөж буй дүрэм, заавар, журмыг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, дүгнэлт гаргах;

4.2.6.Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, шаардлагатай тохиолдолд асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлага танилцуулах;

4.2.7.Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

4.2.8.Хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

4.2.9.Хяналт шалгалтын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах, баримт бичиг, мэдээллийг зөвхөн дотоод хяналтын үйл ажиллагаанд ашиглах;

4.2.10. Мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх;

4.2.11. Аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандах бөгөөд хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах.

#### ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, хяналтын ажилтны гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл шалгуулсан газар, салбар нэгжийн удирдлага, албан тушаалтан гомдлоо "МТЗ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захиралд гаргана.

5.2. Хөндлөнгийн байгууллага, холбогдох мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтад татан оролцуулан дүгнэлт гаргуулж болно.

5.3. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

#### ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Хяналтын ажилтан нь хууль тогтоомж зөрчсөн, компанийн дотоод дүрэм болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлаа чанаргүй, дутуу гүйцэтгэсэн бол түүнд холбогдох хууль тогтоомж, компанийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.